

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ГАЗРЫН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ
ЧАДРААБАЛЫН ӨСӨХБАЯРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ ХҮРЭЭНД”							
1.	Арга хэмжээ 1.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт хийх, дүнг илтгэх хуудсаар танилцуулах;	Удирдамжийн дагуу хяналт шалгалт явуулсан тоо -Дүнг танилцуулсан илтгэх хуудас, дүгнэлтийн тоо	100%	100%	Тайлант хугацаанд байгууллагын даргын баталсан 2024 оны 1-05/09, 1-05/12, 1-05/13, 1-05/14, 1-05/19 дугаарын удирдамжаар хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл хүссэн 6 улсын 16 гадаадын иргэдэд хяналт шалгалт хийж, хяналтын улсын байцаагчийн дүгнэлт үйлдэн мэргэжлийн зөвлөлийн хурлаар оруулсан. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 1/503 дугаартай албан бичгээр гаргасан хүсэлтийн үндсэн дээр төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан шонхорын Ажлын хэсэг байгуулагдаж, Байгаль, орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 01/18 дугаарын “Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамж”-ийн дагуу 15 улсын 79 гадаадын иргэнийг шалган илэрсэн зөрчлийг	5-12 сар	

					шийдвэрлэж, тухай бүр илтгэх хуудсаар танилцуулж, ХЗДХЯ, БОУАӨЯ-нд хүргүүлсэн. Байгууллагын даргын 1-05/08, 1-05/11, 1-05/16 дугаарын удирдамжаар нийслэлийн хэмжээнд 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг 25 аж ахуй нэгж байгууллагын 71 гадаадын иргэнийг шалгаж, тухай бүр илэрсэн зөрчлийг шийдвэрлэж ЗШШГ-ын даргад илтгэх хуудсаар танилцуулсан.		
2.	Арга хэмжээ 1.2. Зөрчлийн болон хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд албан шаардлага өгөх, хэрэгжилтийг хангуулах, гадаадын иргэний виз, бүртгэл мэдээллийн санд тухай бүр бүртгэх;	-Албан шаардлагын тоо -Үнэн зөв бүртгэлд хамруулсан гадаадын иргэн, уригчийн тоо	100%	100%	4 аж ахуйн нэгж, байгууллагад гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн 2024-УБ05/007-009, УБ05/007-010, УБ05/007-016, УБ05/007-017 дугаартай "Албан шаардлага" өгсөн.	5-12 сар	
3.	Арга хэмжээ 1.3. Оршин суух зөвшөөрөл олгохоос болон зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзсан тохиолдолд гарах сануулга өгөх, гадаадын иргэний виз, бүртгэл мэдээллийн санд тухай бүр бүртгэх;	-Гарах сануулга өгсөн тоо -Үнэн зөв бүртгэлд хамруулсан гадаадын иргэний тоо	100%	100%	Виз, зөвшөөрлийн газраас шилжүүлсэн хөрөнгө орвчлалт нь бодитой эсэх, ийн нэр дээр К1 ангиллын олон удаагийн виз хүссэнийг шалгаж, богино хугацаагаар сунгах 1, татгалзах 2 дүгнэлт үйлдэж, буцаан шилжүүлсэн.	5-12 сар	
4.	Арга хэмжээ 1.4. Зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах, шийдвэрлэх;	-Хяналт шалгалт явуулсан, гомдол, мэдээллийг шалган шийдвэрлэсэн тоо	100%	100%	Аж ахуй нэгж байгууллагаас Зөрчлийн талаар амаар болон харилцаа холбооны хэрэгслээр ирүүлсэн 113 гомдол, мэдээллийг хүлээн авч прокурорын бүртгэлд бүртгүүлэн шийдвэрлэсэн.	5-12 сар	

5.	Арга хэмжээ 1.5. Байгууллагын мэдээллийн сайтад байрлах immigration.gov.mn/map объектын судалгааны програмд аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдээллийг оруулах, баяжилт хийх;	-Хяналт шалгалтын ажиллагаанд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын байршлын талаарх мэдээлэлд баяжилт хийсэн тоо	100%	100%	Байгууллагын мэдээллийн сайтад байрлах immigration.gov.mn/map объектын судалгааны програмд тайлант хугацаанд шалгасан 3 аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдээллийг оруулан баяжилт хийсэн.	5-12 сар	
6.	Арга хэмжээ 1.6. Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил гаргасан гадаадын иргэн, уригчийн зөрчлийг шийдвэрлэх;	-Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа явуулсан тоо -Торгох шийтгэл оногдуулсан мөнгөн дүн	100%	100%	Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил гаргасан 90 аж ахуй нэгж байгууллага, хувь хүнээр 23 гадаадын иргэнд нийт 79,770,000₮-ийн торгууль оногдуулсан.	5-12 сар	
7.	Арга хэмжээ 1.7. Гадаадын иргэнийг хуульд заасан үндэслэлээр хяналтын улсын байцаагчийн шийдвэрээр 6 цаг, шүүгчийн захирамжаар саатуулах, сунгах, суллах, хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх, саатуулагдсан гадаадын иргэний хувийн хэргийн бүрдлийг хангах	-Хуульд заасан үндэслэлээр саатуулах -Холбогдох байгууллагыг мэдээллээр хангах -Саатуулсан болон сулласан гадаадын иргэний тоо	100%	100%	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн дугаарын захирамжаар гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.3-т зааснаар саатуулагдсан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 1 иргэнийг мөн шүүхийн шүүгчийн энэ оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн дугаарын захирамжаар суллаж, эх оронд нь хуяглан хүргэсэн.	5-12 сар	
8.	Арга хэмжээ 1.8. Хуульд заасан үндэслэлээр зөрчил гаргасан гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, албадан гаргахаас чөлөөлөх болон албадан гаргасан шийдвэрийг цуцлах тухай дүгнэлт үйлдэх, холбогдох шийдвэрийн биелэлтийг хангах;	-Хуульд нийцүүлэн дүгнэлт үйлдэх -Шийдвэрийг хэрэгжүүлсэн тоо	100%	100%	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2, 37.1.7-д заасан үндэслэлээр БНКазахстанУ-ын 1, БНФилиппинУ-ын 2, БХНАУ-ын 6 иргэнийг албадан гаргах, мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.9 дэх хэсэгт заасан үндэслэлээр ОХУ-ын 1 иргэнийг Монгол Улсаас албадан	5-12 сар	

					гаргахаас чөлөөлөх дүгнэлт үйлдэж, танилцуулсан.		
9.	Арга хэмжээ 1.9. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх;	Өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн тоо	100%	100%	Тайлант хугацаанд 10 аж ахуй нэгж байгууллага, 5 иргэн нийт 15 өргөдөл, гомдлоор ирүүлсэн хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариуг тухай бүр албан бичгээр хүргүүлсэн.	5-12 сар	

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах шийдвэрийг хэрэгжүүлэх журам”-ын төслийг боловсруулж, батлуулах”;	Журмын төсөл боловсруулах, удирдлагад танилцуулах	-	Журмын төсөл боловсруулж, батлуулсан байна.	Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор шаардлагатай тохиолдолд хилийн боомт болон харьяалах, эсхүл холбогдох улсад хүргэх “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах шийдвэрийг хэрэгжүүлэх журам”-ын төслийг боловсруулан нэгжийн даргад танилцуулж, Байгууллагын даргын А/243 дугаар тушаалаар батлуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.	5-12 сар	
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд чиглэсэн хяналтын улсын байцаагчийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулахад оролцож, мэдээлэл хүргэх.	Зохион байгуулсан сургалт хийсэн тоо	-	Албан хаагчдад хяналт шалгалтын чиглэлээр сургалт хийж, мэдээлэл хүргэсэн байна.	Байгууллагын даргын энэ оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 01-02/54 дугаарын удирдамж, сургалтын хөтөлбөрийн дагуу төв, орон нутгийн хяналтын улсын 17 байцаагчид Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох журмын хүрээнд сургалт орсон.	5-12 сар	
3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3.	Зохион байгуулсан	-	Албан хаагчдад хяналт	Байгууллагын даргын энэ оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 01-02/60 дугаарын удирдамж, сургалтын		


	Шинээр томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалт зохион байгуулахад оролцож, мэдээлэл хүргэх.	сургалт хийсэн тоо		шалгалтын чиглэлээр сургалт хийж, мэдээлэл хүргэсэн байна.	хөтөлбөрийн дагуу төв, орон нутгийн шинээр томилогдсон 19 мэргэжилтэн, байцаагчид Зөрчлийн болон гадаадын иргэнийг албадан гаргах ажиллагааны тухай ойлголтын талаар сургалт орсон.	5-12 сар	
4.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Бусад байгууллагын албан хүсэлтээр Монгол Улсын виз, бүртгэл, зөрчлийн талаар мэдээлэл хүргэх	Зохион байгуулсан сургалт хийсэн тоо	-	Мэдээлэл хүргэсэн байна.	Монгол банкны Санхүүгийн мэдээллийн албаны ирүүлсэн хүсэлтийн дагуу энэ оны 06 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын виз, бүртгэлийн талаар, БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамнаас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу энэ оны 11 дүгээр сарын 28-ны өдөр цахим шилжилтийн талаар Виз, зөвшөөрлийн газрын ахлах мэргэжилтэн А.Баттөрийн хамт мэдээлэл хүргэж, сонирхсон асуултад хариулсан.	5-12 сар	

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 2.1. А ангиллын үнэмлэх олгох дамжаанд суралцах;	Суралцсан кредит цаг	-	Шалгалтад тэнцсэн байна.	А ангиллын үнэмлэхийг 2024.07.19-ний өдөр авсан.	5-12 сар	
2.	Арга хэмжээ 2.2. Гадаадын иргэний талаарх хууль тогтоомжид оруулсан нэмэлт, өөрчлөлт болон эсхүл шинэчлэн баталсан захиргааны хэм хэмжээний актуудыг судлах, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх.	Эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн байна.	100%	Эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн байна.	Хууль тогтоомж болон байгууллагын даргын баталсан дотогш чиглэсэн захиргааны хэм хэмжээний актыг тухай бүр уншиж судалсан.	5-12 сар	

ТАЙЛАН ГАРГАСАН:

Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч

 (Ч.Өсөхбаяр)

2024.12.05

2024